



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ ХИЙЛГЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: *Гэнэтийн ослын даатгал*

Тендерийн дугаар: **ЦДУС/202001165**

**УЛААНБААТАР ХОТ
2020 он 07 дугаар сарын 29-ний өдөр**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020/07/29

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Гэнэтийн ослын даатгал” гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Даатгалын үнийн санал ирүүлэх гэнэтийн ослын даатгалд хамрагдах ажилтнуудын тоо болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30,000 /гучин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг 2020 оны 08 дугаар сарын 05-ны 10:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр 3 дугаар давхар 309 тоотод 2020 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 10:10 цагт тендерийг нээнэ.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Хан-Уул дуурэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар 309 тоот.

**Худалдан авах ажиллагаа, Ханган нийлүүлэлтийн хэлтэс.
Утас: 99248880. Факс:976-70043287**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дунд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дунг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
 - 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дунг тендерт

оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

- | | |
|--|--|
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |

XXX

Хоёр ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; - Сүүлийн 2 жилийн туршилагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; - Ашигтай ажилласан байх жилийн тоо; /сүүлийн нэг жил/ - Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/ - Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байх; /Цахим системээс татаж үзнэ/ - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт; - Шүүхийн тодорхойлолт; - Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт; - Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт. (Улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээр) - Гэрээний загвар хавсаргаж ирүүлнэ; /Гэрээнд ажиллагсдын гэнэтийн ослын даатгалын нөхцөл шаардлага тодорхойлолтын дагуу тусгасан байх/ - Компанийн дэлгэрэнгүй танилицуулга; <p>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдөр цахим системээр илгээх.</p> <p>Цаг: 10 цаг 00 минут.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот-21013, Хан-Уул дуурэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДУС” ТӨХК-ийн төв байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3-н давхар, 309 тоот</p> <p>Огноо: 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдөр нээлт хийнэ.</p> <p>Цаг: 10 цаг 10 минут</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ” ЦДУС/202001165</p>
Бусад:	Хөнгөлөлт урамшуулалт үзүүлэх бол албан бичгээр ирүүлнэ.

ДААТГАЛД ХАМРАГДАХ АЖИЛЧДЫН ТОО

Нийт ажиллагсдын тоо 1302 /нэг мянга гурван зуун хоёр/

БАТЛАВ. ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Б.ДАШДАВАА

ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛЫН НӨХЦӨЛ ШААРДЛАГА, ТОДОРХОЙЛОЛТ

1. Байгалийн /газар хөдлөлт, цасан болон шороон шуурга, хүчит салхи, үер, хөрсний нуралт, цөмрөлт, аянга, аадар бороо, мөндер, ой хээрийн түймэр, усанд живэх, шавар намагт шигдэх зэрэг/ эрсдэл
2. Ахуйн /унаж бэртэх, хальтрах, зам тээврийн аюул осолд өртөх, элдэв юманд цохиулах, хавчуулах, түлэгдэх, хорт хийнд хордох зэрэг/ эрсдэл
3. Үйлдвэрлэл техникийн /машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах үед болон цахилгаан хүчдэл, дэлбэрэлт, шаталт зэргийн нөлөөгөөр учирсан осол, химийн бодист хордох, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдснээс гарч болох осол зэрэг/ эрсдэл
4. Техниктэй харьцах үеийн /унадаг дугуй, мотоцикл, автомашин зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл, төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, унах, живэх зэрэг/ эрсдэл
5. Мал амьтадын нөлөөгөөр үүсэх /малд дайруулах, мөргүүлэх, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах тэрчлэн араатан амьтад, нохойд бариулах, морь малнаас унах зэрэг/ эрсдэл
6. Гадны нөлөөллийн /бусдын гэмт үйлдлийн улмаас сум, хутга мэсэнд өртөх, хорлогдох, зодуулах, цохиулах зэрэг гэмтэх/ эрдсэл.
7. Урлаг, спортын бэлтгэл, дасгал сургуулилт хийх болон уралдаан, тэмцээн, тогтолтын үед бэртэж гэмтэх

ХЯНАСАН. ХМХ-ИЙН ДАРГА

Я.МӨНХТӨР

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН. ХМХ-ИЙН ҲАБЭАИ

М.БАЛТ

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮННИЙ САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				